



МОНГОЛ УЛСЫН
ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН
ДҮГНЭЛТ

2018 оны 9 сарын 21 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай
хуулийн зарим заалт Үндсэн хуулийн
холбогдох хэсгийг зөрчсөн эсэх
маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 12.30 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Чинбат даргалж, гишүүн Ш.Цогтоо /илтгэгч/, Д.Солонго, Б.Буяндэлгэр, Ц.Нанзаддорж нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн Ш.Алтангадас, Ө.Эрдэнэ-Очир, Т.Мөнх-Эрдэнэ, Д.Гантөмөр нар оролцож, Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй болно.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1, Тавьдугаар зүйлийн 2, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн зарим заалтыг тус тус зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 25 дугаар хорооны оршин суугч, иргэн Ө.Эрдэнэ-Очир, Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны оршин суугч, иргэн Ш.Алтангадас нар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ...” гэж заасны дагуу хууль бусаар хохирсон гэдэг нь шүүхээр тогтоогдсон бол хохирол учруулсан этгээдээс нөхөн төлүүлж зөрчигдсөн эрх, ашиг сонирхлоо нөхөн сэргээлгэх эрхийг баталгаатай эдлэхээр заажээ. Иргэний “шүүхэд гомдол гаргаж хохирлоо нөхөн төлүүлэх” эрх нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хангаж хамгаалах гол баталгаа болж байдаг билээ.